



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА,
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХҮЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 9 өдөр

Дугаар 11/77

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4, 50 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 181 тоот тогтоолоор батлагдсан “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчit аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийн 6.5.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан “Хоёр жил тутмын ил тод байдлын тайлан, үндэсний тавдугаар тайлан илтгэл боловсруулах төслийн санхүү, технологи хөгжүүлэлт, дамжуулалт, чадавхи бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэгийн талаарх тайлан мэдээ бэлтгэх ажил”, “Хоёр жил тутмын ил тод байдлын тайлан, үндэсний тавдугаар тайлан илтгэл боловсруулах төслийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, дасан зохицохтой холбоотой хийгдэх ажил”, “Зөөврийн компьютер худалдан авах ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Х.Батболд - Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Гишүүн: Б.Лхагвадорж - ТББ-ын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Д.Чойжилсүрэн - Төсөл, хөтөлбөрийн хэлтсийн мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны даргад үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

J. Chiehland

Ж.ЧОЙХАНД

